



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 380

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.2, 6.2.3, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дархан-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 10 нэрийн нийт 29,204,232.36 (хорин есөн сая хоёр зуун дөрвөн мянга хоёр зуун гучин хоёр төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Дархан-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Энхболд, гүйцэтгэх захирал Б.Баясгалан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, хоёрдогч түүхий эд болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

300723

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 07 дугаар сарын 06-
ний өдрийн 380 дугаар тогтоолын
хавсралт

**"Дархан-АЗЗА" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас
хасах хөрөнгийн жагсаалт**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл дүн (төгрөг)
1	Санхүүгийн программ	2005	ш	1	900,000.00	900,000.00
2	Модон хөл	2004	ш	1	520,058.00	520,058.00
3	Ойлгогч призм	2004	ш	1	763,763.00	763,763.00
4	хөнгөн цагаан хөл	2004	ш	1	284,611.00	284,611.00
5	Хэвгийн хэмжигч	2004	ш	1	104,580.00	104,580.00
6	Электрон нивлер	2004	ш	1	2,698,850.00	2,698,850.00
7	Электрон нивлерийн рейк	2004	ш	2	710,941.00	1,421,882.00
8	Электрон тахеометр	2004	ш	1	20,587,952.00	20,587,952.00
9	Компьютер Dell	2003	ш	1	1,662,636.36	1,662,636.36
10	Сандал	2003	ш	1	259,900.00	259,900.00
				11		29,204,232.36
	Нийт дүн			11 (арван нэг)		29,204,232.36 (хорин есөн сая хоёр зуун дөрвөн мянга хоёр зуун гучин хоёр төгрөг гучин зургаан мөнгө)